



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 235

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

“Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн 2018 он, 2019 оны 3 дугаар улирлын байдлаарх удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар шалгалтаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалтыг зөрчиж 3,106.7 сая төгрөгийн найдваргүй авлага үүсгэсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8, 48 дугаар зүйлд заасныг зөрчиж 467.1 сая төгрөгийн худалдан авалт хийсэн зэрэг нийт 3,573.8 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн 2018 он, 2019 оны 3 дугаар улирлын байдлаарх удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн гүйцэтгэх захирал М.Алтан-Очирт дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах;

2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг удаа дараа зөрчсөн болон түүнд хяналт тавьж ажиллах үүргээ хангалтгүй биелүүлсэн холбогдох албан тушаалтан нарт хариуцлага тооцох;

2.3. Компанийн хөрөнгийг зохистой удирдаж, авлага, өглөгийг бууруулж ажиллах, нэг жилээс дээш хугацаатай авлагыг барагдуулах ажлын хэсэг байгуулж, шүүхийн журмаар нэхэмжлэх;

2.4. Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалтын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох талаар санал боловсруулан танилцуулж байх;

2.5. Анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврыг баримталж, төлбөрийн баримтыг цахим хэлбэрээр авч байх;


2.6. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

300379

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.


ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСЭЙН
ДАРГА



З.МЭНДСАЙХАН

Ц. ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 05 дугаар сарын 03-ний өдрийн
135 дугаар тогтоолын хавсралт

“Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн 2018 он, 2019 оны 3 дугаар улирлын байдлаарх
удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн
зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Зөрчлийн дүн /Сая төгрөгөөр/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх хэсэгт заасныг зөрчиж найдваргүй авлага үүсгэсэн	Гүйцэтгэх захирал, Дэд, захирал, Санхүү, хөрөнгө оруулалтын газар, нягтлан бодох бүртгэлийн алба	3,106.7	Авлага барагдуулах ажлын хэсэг байгуулж, шүүхийн журмаар шийдвэрлэх, харилцагчтай байгуусан гэрээний үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллах, найдваргүй авлага үүсгэхгүй байх.
2	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8, 48 дугаар зүйлд заасныг зөрчиж худалдан авалт хийсэн	Гүйцэтгэх захирал, Дэд, захирал, Санхүү, хөрөнгө оруулалтын газар, Хөрөнгө оруулалт, төсвийн алба	467.1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хэлбэрээр нээгттэй ил тэд зарлаж, журмын дагуу зохион байгуулж, тэгтоосон хугацаанд тайлан гарган хүргүүлж байх.
Зөрчил, дутагдлын нийт дүн			3,573.8	